

МОНГОЛ СУДЛАЛЫН НЭРТ ХҮМҮҮС

ОУМЭ-ийн V их хуралд зориулав.

НИКИТА ЯКОВЛЕВИЧ**БИЧУРИН (Иакинф)****(1777—1853)**

Н.Я. Бичурин бол дэлхийн нанхиад судлалын нэрт эрдэмтэн, Оросын дорнодахины судлалыг үндэслэгчийн нэг юм. Тэр хэдийгээр шашны санваартан боловч, дэвшилтэт үзэлтэй хүн байв. Дэлхийн дорно дахины судлаачдын тэргүүн эгнээнд нэр нь зүй ёсоор орсон энэ хүн Оросын эрдэмтдийн дотроос эрдмийн дээд цол, шагнал хүртсэн анхны нанхиадач байлаа. Н.Я. Бичурин одоогоос 210 жилийн өмнө 1777 оны 8-р сарын 29-нд Казани мужийн Чебок сар хошууны Акулево тосгонд, ядуу тариачны гаралтайн учир овоггүй агсан ламын гэрт төржээ. Никита багадаа дууны сургуульд орж суралцаж байгаад, 1785 онд Казанийн шашны тусгай дунд сургуульд элсэн орж, төрсөн тосгоныхоо нэрээр Бичурин хэмээх овогтой болжээ. Оролдлого сайтай, авъяаслаг хүү Никита шашны сургуульд байхдаа латин, герман, франц хэлийг богинохон хугацаанд сайн сурч чөлөөтэй ярьдаг болжээ. Тэр сургуулиа амжилттай төгссөн учир түүнийг гэлэн болгож Иакинф гэсэн сахилын нэр хүртжээ. Мөн 1807 онд Оросын Үнэн алдартны шашны эрх барих байгууллагаас Иакинфийг Бээжин дэх Оросын шашныг номлох есдүгээр газрын даргаар томилжээ. Энэ үеэс тэрбээр Хятадын ард түмний түүх, эдийн засаг нийгмийн байгуулал, соёл, зан заншилтай танилцах зам нээгджээ. Хятадад 14 жил суухдаа хятад хэлийг гойд эзэмшиж хуучин судар бичгийг цуглуулан судалж хамаг анхаарлаа шинжилгээний ажилд хандуулж улмаар шашин номлох газрын даргын үүрэгт ажлаа цалгардуулсан учир үнэн алдартны шашны эрх баригчдын дургүйцлийг төрүүлжээ. Иймд Бичуринийг Петербургт буцаан авчраад, 1822 оны 2-р сард шүүх хурлаар оруулж, «Мөргөл хийхийг цалгардуулж хуулийн эсрэг хэрэг үйлдсэн» гэсэн ял тулган Валаамын хийдэд цөлжээ. Бичурин Хятадаас буцаж ирэхдээ өөрийн цуглуулсан шинжилгээний асар их материалаас гадна 15 тэмээ (400 пүү) ном, судар авчирсан бөгөөд цөллөгөнд 4 жил суухдаа тэр материалаа эмхлэн боловсруулж заримыг нь хэвлэлд бэлтгэжээ. Тэр үед Оросод хятад хэлийг Бичурин шиг сайн мэддэг хүн ховор байсан учир 1826 онд түүнийг цөллөгөөс чөлөөлж Гадаад Явдлын яаманд орчуулагчаар ажиллуулжээ. Бичури-

ны амьдралын шинэ үе эндээс эхэлж, тухайн үеийнхээ дэвшилтэт үзэлтэй хүмүүстэй танилцан нөхөрлөж, судалгааны бүтээлүүдээ шаргуу туурвиж эхэлсэн юм. Тэр юуны өмнө Хятад болон Төв, Дундад Азийн бусад улс түмний түүх, угсаатны зүй, соёл газарзүйн тухай хятад сурвалжийн мэдээ хэрэглэгдэхүүнийг орчуулан нийтлүүлж байв. Нийт 60 гаруй биеэ даасан бүтээл нийтлүүлсний нэлээд нь Хятадын ард түмний түүх, соёл, хэлийг судлахад зориулагджээ. Тэр дорно дахины сурвалжуудыг эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулахдаа юуны өмнө өөрийн үнэлэлт дүгнэлт өгдөг байжээ. Түүний хятад хэлнээс орчуулсан бүтээлүүдээс зөвхөн «Тунцзянь ганму» хэмээх түүх л 17 боть байсныг бодоход хичнээн их зүйл хийсэн нь тодорхой. Тэр үед өрнөдийн түүхчид дорно дахины түүхийг зөвхөн гол төлөв грек сурвалжаар төсөөлдөг байсан учир өрөөсгөл дүгнэлт хийх явдал нэлээд байжээ. Гэтэл Бичурины орчуулгууд тэр грек сурвалжуудыг сэлбэн судалгааны баазыг өргөтгөж, олон зүйлийг тодруулах бололцоо буй болгосон байна. Түүний орчуулгуудын тухай А.И. Бернштам, тэр хятад сурвалжуудыг системтэй, тууштай орчуулсан европын анхны эрдэмтэн бөгөөд зөвхөн үүнийг нь орос болон дэлхийн шинжлэх ухааны өмнө түүний байгуулсан гавъяа гэж болно¹ хэмээн үнэлсэн байна. Тэр бас тухайн үеийн Хятад, Манж Чин улс, түүний харъяат байсан орнуудын тухай биеэ даасан олон бүтээл туурвижээ. Тухайн үеийн Оросын 20 орчим тогтмол хэвлэлд Бичурины бүтээлүүд нийтлэгдэж, бас Европын олон оронд хэвлэгдэж байв. Бичурин хятад хэлний толь зохиогоод дөрвөн удаа хуулбарлан засч байжээ. Түүний хятад судлалд оруулсан хувь нэмрийг тодорхойлж, В.В. Бартольд, «Бичурины бүтээлийн ачаар Оросын хятад судлал бүр 1851—1852 онд баруун Европын хятад судлалыг гүйцэн түрүүлсэн юм» гэж үнэлж байжээ.

Н. Я. Бичурин Оросын монгол судлалын үндсийг тавьсан эрдэмтний нэг. Тэрбээр нийт Азийн ард түмнүүдийн түүх, угсаа гарал, соёл иргэншлийн талаар туурвисан олон зохиолдоо, Монголын тухай асуудлыг хөндөн өгүүлж байснаас гадна 4 том бүтээлээ шууд монгол судлалд зориулжээ.²

1828 онд нийтлэгдсэн түүний анхны тусгай ном нь «Монголын тухай тэмдэглэл» байв.

Бичурины хамгийн сүүлчийн том бүтээл нь 1851 онд хэвлэгдсэн «Эрт цагт Дундад Азид нутаглаж байсан ард түмнүүдийн тухай мэдээний цоморлиг»³ юм. Бичурин Монголын тухай бүтээлүүдээ, тухайн үед монгол судлалын өмнө тулгарч байсан зорилтуудад зохих хариу өгөхийн хамт, судалгааны шинэ шинэ асуудлыг дэвшүүлэн тавьсан нь дэлхийн Монгол судлалыг хөгжүүлэхэд дорвитой хувь нэмэр болжээ. Бичурин монголчуудын үүсэл гарал, монгол хэмээх нэртэй ард түмэн анх түүхийн тавцанд гарч ирсэн явдал хоёрыг ялган салгаж авч үзэх ёстой. Учир нь Монголчуудын үүсэл гарал нь бүр МЭӨ III

1 Н. Я. Бичурин (Иакинф) Собрание сведений о народах, обитавших в Средней Азии в древние времена. М-Л. 1950, 12-р тал

2 Записки о Монголии, сочиненные монахом Иакинфом. С прилож, карты Монголии и разых костюмов. т — СПб., 1828. История первых четырех ханов из дома Чингисова. Переведено с китайского монахом Иакинфом. Спб 1829 Описание Чжунгарии и Восточного Туркестана в др. и нынешнем состоянии Спб. 1829. Историческое обозрение ойратов или калмыков с XV столетия до наст. времени Сочинено монахом Иакинфом. Спб., 1834.

3 Бичурин Н. Я. Собрание сведений о народах, обитавших в Средней Азии в древние времена. В 3-х частях. Спб, 1851. Изд. 2.Т.1 П. М— 1950—1953

мянганы дунд үед холбогдох бөгөөд харин монгол нэртэй угсаатан түүхийн тавцанд IX зуунд гарч ирээд, XII зуунд хүчирхэгжээд, XIII зууны эхээр Монгол улс байгуулагдсан юм гэсэн дүгнэлт хийжээ. Тэрбээр Хятадын түүхийн баялаг хэрэглэгдэхүүнийг түшиглэн, Хүннү зэрэг Төв Азийн нүүдэлчдийн зарим төр улсыг байгуулагчид нь Монголчуудын дээд өвөг байсан юм гэж үзсэн юм. Энэ дүгнэлт нь тухайн үед ноёрхож байсан, хүннү нар түрэг угсаатан байсан гэсэн. Дегинь нарын үзэлд анх удаа хүчтэй няцаалт өгсөн төдийгүй, одоо болтол шийдвэрлэгдээгүй маргаантай байгаа онолын энэ том асуудлыг зөв шийдвэрлэх иш үндсийг тавьж өгсөн юм.

Германы эрдэмтэн Клапрот хүннү нарын гарлын талаар Бичуринтай ширүүн маргаж, зөвхөн «Монголын тухай тэмдэглэл» номынх нь тухай гурван сэтгүүлд шүүмж бичиж байжээ. Бичурин түүнд тухай бүрт нь эхлээд Оросоор няцаалт хийж, сүүлд нь францаар нэлээд ноцтой хариулт өгчээ. Тэр Монголын түүхийн талаарх Хятад сурвалжийн арвин их мэдээг орчуулан, эрдэмтдийн хүртээл болгосон нь тухайн үеийн монгол судлалд шинэ үзэгдэл болсон юм. XIX зууны тэргүүн хагаст Бичурин Монгол оронд ирж, нүдээр үзсэн зүйлээ тодорхой тэмдэглэн үлдээсэн нь одоо ч судалгааны чухал ач холбогдолтой хэвээр байна. Тэр монгол хэлийг ямар нэг хэмжээгээр мэддэг байсан бололтой бөгөөд 1831, 1835 онд Хиагтад ирэхдээ, монгол хэлнийхээ мэдлэгийг дээшлүүлэхийг мэрийж байсан, мөн дараа нь нэг хүнтэй хамтран «Монгол-Хятад Толь» бичгийг оросчилж байсан тухай мэдээ байна. Бас монгол судлалын томхон мэргэжилтний хувьд, тухайн үед Монголын талаар өрнөдөд гарч байсан ном, зохиолыг алдалгүй үзэж, нэлээдэд нь шүүмж бичиж, үнэлж цэгнэхийн хамт алдаа мэдгийг нь залруулдаг байжээ.

Бичурины эдгээр бүтээл нь Н. П. Шастинагийн үнэлснээр, тухайн үеийн монгол судлалын шинжлэх ухааны шинэ том алхам болсон юм.⁴

Бичурин зөвхөн монгол төдийгүй Азийн томхон ард түмнүүдийн түүхийг дэс дараатай, улстай судлахад ихээхэн анхаарч, юуны өмнө Төвд, Туркестаныг судлах шаардлагатай хэмээн үзээд, төвд, манж, солонгос, Японы түүхийн талаар нэлээд судалгаа хийсэн байна.

Никита Яковлевич дэлхийн дорноддахины судлалыг арвин их мэдээ хэрэглэгдэхүүнээр баяжуулаад зогссонгүй, онолын шинэ сэдвүүдийг дэвшүүлэн тавьж, заримд нь ул үндэстэй хариу өгсөнд түүний шинжлэх ухааны өмнө байгуулсан гавъяа оршино. Бичурины эрдэм судлалын ажлыг үнэлж, түүнд Демидовын шагналыг 4 удаа хүртээж, 1828 онд Оросын Шинжлэх ухааны Академийн сурвалжлагч гишүүнээр, 1831 онд Парис дахь Азийн нийгэмлэгийн гишүүнээр, 1837 онд Оросын Газар зүйн нийгэмлэгийн сурвалжлагч гишүүнээр тус тус сонгож байжээ. Тэр 1853 оны 5-р сарын 23-нд Александро Невскийн Лавр (сүм)-д нас нөгчижээ. Түүний шарилын бунхан дээр нь энэ хүн «Алдар нэрээ мөнхжүүлсэн түүхийн бүтээлүүдээ уйгагүй хичээнгүйлэн туурвисан юм» гэсэн бичигтэй хөшөө босгосон ажээ. Бичурины хийсэн бие даасан судалгаа, орчуулгууд нь түүний дараа, дараагийн дорно дахины судлаачдад шинжилгээний өв болсоор байна.

Ц. Энхчимэг

ВАНЧИНБАЛЫН ИНЖИНАШ БА ТҮҮНИЙ ЗОХИОН БҮТЭЭЛ

Мэндэлсний нь 150 жилийн ой энэ онд тохиолдож буй В. Инжинаш бол XIX зууны үеийн Монголын түүх, үргэлжилсэн үгийн зохиолын нэрт төлөөлөгч мөн. В. Инжинаш зохиол бүтээлдээ Монголын эртний зохиолд олонтаа тохиолдох үлгэр домог, түүхэн бодит баатруудын үйл явдлын өгүүлэмжийг улам баяжуулж, уран сэтгэлгээний дүрүүдийг бүтээсэн нь Монголын утга зохиолын хөгжилд гарсан шинэ үзэгдэл байлаа.

XIX зууны үед Монгол орон улс төр, эдийн засгийн талаар Манж Чин улсын хараат бөгөөд оюун санааны бүхий л салбар нь шарын шашны бурангуй үзлийн нөлөөнд автсан байжээ. Буддын шашны сургаал номлол, Энэтхэг-Төвдийн үлгэр домог уран зохиолд нөлөөлж, «Монголчууд Чингис хаан нь Гэсэр богдын нэгэн дүр юм гэж итгэхэд хүрч байсан»¹ тэр цагт Инжинаш зохиол бүтээлээ туурвиж «үндсээ үл мэдэх нь адгуус, түүхээ үл мэдэх нь сохор номин лугаа адил болно» гэж бичин Монгол үндэснийхээ түүх соёлын уламжлалыг эрхэмлэн хайрлахгүйгээр ирээдүйгээ итгэл төгс холч харахгүй хэмээн сургаж байлаа. Инжинашийн зохиолууд ялангуяа «Хөх судар» роман монгол үндэстэн бол өөрийн төрхтэй, биеэ даасан улс байсан юм гэдгийг тусган харуулах сэтгэлийн үүднээс Монголын тулгар төр тогтсон үеийн түүхийг уран яруу өгүүлж, харийн түрэмгийлэгчдийн ноёрхлоос ангижирч, тусгаар улс гэрээ сэргээн байгуулах гэсэн ард түмнийхээ чин хүсэл эрмэлзлэлийг тод томруун тусгасан байдаг.

Ванчинбалын Инжинаш 1837 оны 5-р сарын 23-нд Өвөр Монголын Зостын чуулганы Түмэд баруун хошуунд төржээ. Түүний эцэг Ванчин бал Монголын түүхийн сурвалж бичгийг судлан үзэж, уран зохиол бичдэг хүн байсан бөгөөд тэрбээр 1830 оноос «Хөх судар» романы эхний найман бүлгийг зохиожээ. Ванчинбалын найман хүүхдийн дөрөв нь монгол болон бусад хэлний бичиг үсгийн боловсролтой, эртний түүхийн ном шастирыг судлан орчуулдаг авъяаслаг бичгийн хүмүүс байв. Ууган хүү, шүлэгч Гуларанс нь «Түргэнээ төвшрөхийг хүснэ», «Өрөөсөн болжмор» зэрэг шүлэг зохиож, 5-р хүү Гүнначүг нь Хятадын «Улаан асрын зүүд» 6-р хүү Сүнвэйданзун «Тунзян ганьму», Гуларанс, Сүнвэйданзун нар «Хүйтэн уулын бичиг» романыг монгол хэлнээ тус тус орчуулжээ.

* Инжинаш гэдэг нь санскрит хэлний «Зана - jana», төвд хэлний «Иш - yishes» хэмээх «билэг гэсэн ижил утгатай санскрит, төвд хоёр үгийг холбосон нэр юм. XIV зууны үеэс Монголд Зана Иш» хэмээх үгийг «Инжинаш» гэж дуудан бичдэг болжээ. (Монголын уран зохиолын тойм. III дэвтэр. УБ. 1968 он)
1 Хангин Гомбожав, Олон улсын монголч эрдэмтдийн II их хурал УБ, 1973 он, 118-р тал

«Хөх судар» түүхэн романыг энэ соёлт гэр бүлийн хамтын бүтээл гэж үзэх явдал байдаг. Гэхдээ «Хөх судар»-ын гол зохиогч нь В. Инжинаш юм. Учир нь Инжинаш 1870 оноос «Хөх судар»-ын бусад бүлгийг бичиж дуусган олны санал зөвлөгөөг авч «Хөх судар» романыг дахин засч найруулан бичсэн байдаг.² Инжинашийн бичгийн хүний авъяас билэг бага наснаас нь тодорч, арав гаруй насандаа «Ижийгээ мөрөөдсөн нь», «Сайхан хур, шинэ бороо», «Қигшмээр хүн», «Хөх хад», «Цагаан үүл», «Улаан тоост уршигт ертөнц», «Өнгөт солонго шингэв» шүлгүүд зохиож, хорин хэдэн насандаа «Улаан өнгөтний нулимс» гэдэг зохиол³ бичсэн нь өнөө хэр мэдэгдэж буй түүний анхны бүтээлүүд юм. Инжинаш тайж язгууртны гаралтай хэдий ч отог жинс зүүж, эрх ямба эдлэлгүй бийр цаастай идэр залуу наснаасаа нөхөрлөн «барын сүүл болж явснаас, батганы толгой болж амьдаръя» хэмээн уран зохиолын үйлст нэгэн биеэ зориулан олон арван шүлэг, өгүүлэл, роман, уран нийтлэл, шүүмж бичжээ. Түүний бичсэн «Эрдэнийн толь», «Гэрийн тэмдэглэл», «Өдрийн тэмдэглэл», «Уяхан хавар», «Тунгалаг зун», «Сэрүүн намар», «Хүйтэн өвөл», «Хос болжмор», «Язгуураа мартаж болохгүй», «Хөх судар», «Нэгэн давхар асар», «Улаанаа ухилах танхим» зэрэг эдүгээ олдоод байгаа олон зохиолуудын уг эхийн үгийн баялаг нь 1 сая 500 мянгад⁴ хүрч байгаа нь Инжинаш төрөлх монгол хэлээ гойд эзэмшсэн уран бүтээлч хүн байсныг харуулж байна.

Инжинашийн зохиолуудаас хамгийн алдартай нь «Хөх судар» роман юм. Романы нэрийг эрт цагт монголчууд «хөх Монгол, Улаан Хятад, цагаан Солонгуд, хар Төвд (Хотон, Уйгур багтана)⁵ гэж байсныг үндэслэн Монголын түүхийн холбогдолтой энэхүү номыг «Хөх судар» гэжээ. «Хөх судар» нь 8 бүлэг дэлгэрэнгүй оршил «Товчит тольт», 69 бүлэгтэй. Үүнд 1—3-р бүлэгт 1162 онд Тэмүүжин мэндэлснээс авахуулаад Бөртэ үжинтэй ураг холбон хуримлах хүртлэх үе, 4—37-р бүлэгт Тэмүүжин тархай бутархай Монголын олон аймгийг нэгтгэж Чингис хаан хэмээн өргөмжлөгдөх үе, 38—60-р бүлэгт Чингис хааны явуулсан аян дайн, түүний таалал төгссөнийг хүртэлх үе, сүүлчийн есөн бүлэгт Өгөөдэй хаан ширээг залгамжилснаас хойшхи 9 жилийн хэрэг явдлыг багтаажээ. Инжинаш «Хөх судар» түүхэн романдаа тайж язгууртны төв удамшлын үзэл санааг баримталж, Монголын ноёрхогч феодал ангийн эрх ашиг, Чингис хааны бүхий л үйл ажиллагааг өргөмжлөн магтаж, түүний харь улсад хийсэн түрэмгий дайн, учруулсан зовлон гамшгийг хааж хаацайлсан талтайг анхаарахгүй байж болохгүй.

Инжинаш «Хөх судар»-ыг бичихдээ «Мандсан төрийн хөх судар», «Цадигчийн эрхт хэтийн үндэс», «Хөх Монголын цадигчийн цадиг», «Алтан үрстийн дөт түүх», «Далай ламын залуусын хурим», «Алтан урагтны сэтгэлийн цэнгэл», «Чингис хааны сул шастир», «Богд Чингисийн орчлонгийн хэлцэл», «Их Юан улсын төвийн судар», «Тунзянь ганьму» зэрэг арван судрыг тулгуур болгосноос гадна монгол ба

2 Хангин Гомбожав, «Хөх сударын нэгэн бичмэл эх-түмэд бичмэл эх» УБ. 1973 он. 118-р тал

3 Энэхүү бүтээлийг гүйцэд бичээгүй, дутуу орхисон зохиол болох тухай Эрдэнэтогтох «Инжинаш түүний уран бүтээл» гэдэг илтгэлдээ дурджээ. ОУМЭ-ийн I их хурал. УБ. 112-р тал

4 Мөн тэнд

5 Х. Буянбат, Инжинаш ба түүний «Хөх судар»-ын тухай. Хайлар хот, 1981 он. 167-р тал

дорнодахины ард түмний соёлын өв уламжлалын доторх эртний шидэт үлгэр домог, баатарлаг туульс, ерөөл магтаал, ардын дуу, хуурын үлгэр, зүйр цэцэн үгсийг зохиолдоо өргөн ашиглажээ. Инжинаш Монголын түүхийн холбогдолтой «Нууц товчоо», «Өнчин хүүгийн сэцэлсэн шастир», «Чингис хааны билэг», «Алунгоо хатны домог», «Аргусун хуурчийн домог», «Оюун түлхүүр», «Лу Алтан товч» зэрэг олон бичиг судрын агуулга, найруулга, дүрүүдийг нарийвчлан үзэж «Хөх судар» романд холбогдол бүхий түүхэн хэрэг явдалд уран санаа ургуулан баяжуулснаас гадна Сайхан сурталт, Оюутсэцэн гэх зэрэг жирийн хүмүүсийн үйл амьдрал, дүр төрхийг бүтээсэн байдаг.

Инжинаш «Хөх судар» түүхэн романдаа монгол үндэстний нэгдлийг эрхэмлэн үзсэнийг «Товчит толтиос» харвал «Зүн зүгээр тав талаар нэгэн төрсөн биеийг өнгөрүүлж төвдөхгүйеэ энэ нэгэн их төвийн Юан улсын судрыг ертөнцийн хооронд дэлгэрүүлэн гаргаж, энэ сударт итгэж энэ бие монгол тоотноо мянга түмэн он ялзаршгүй, барагдашгүй, арилшгүй хоцроосугай гэсэн санаанаас болсон биш үү» гээд

Буулгаагүй модонд хурц хөрөө хэрэгтэй

Бууж унасан модонд уран модчин хэрэгтэй

Байгуулаагүй төрд баатар жанжин хэрэгтэй

Байгуулж бүрдсэн төрд багшлах мэргэд хэрэгтэй⁶ гэж шүлэглэсэн нь зохиолын агуулгыг тодорхой болгож байна.

Инжинаш «Хөх судар» романыг бичихдээ бүлэг бүрийн өмнө уг бүлгийн үндсэн агуулгыг товч илэрхийлэх зорилго бүхий цөөн мөрт шүлгийг бичжээ. Тухайлбал 7-р бүлгийн эхэнд:

Найлзуур бургасан шугуйд алтан гургалдай мэдээ хүргэнэ

Найман аймгийн улсад Хонгорзул элбэрэлийг мэднэ гэж бичсэн нь зохиомж, уран сайхны өвөрмөц яруу шигтгээ болсон юм. Инжинаш романы зангилаа, тайлал хэсэгт шүлэглэх буюу хүүрнэн нэмэлт тайлбар хийснээс гадна хүмүүсийн дүр байдлыг зураглан үзүүлэхдээ шууд дүрслэлийн аргыг олонтаа хэрэглэжээ. Зохиолд Чингис болон түүний өрлөг жанжин нарын дүрийг товойлгон гаргахдаа ухаалаг, хүлээцтэй, эрэлхэг дайчин чанартайгаар уран яруу дүрсэлсэн бол тэдний эсрэг талын дүрийн зусар бялдууч, омгорхог бардам, балмад дээрэнгүй төрхийг нь үнэгний шиншилт, чонын харалттай гэх мэт үгээр дүрсэлжээ. Романд хошин ёгтоор дүрийг тодруулсан хэсэг ч байдаг. «Хөх судар»-ын 2-р бүлэгт Найманы Наран хаан (нар - гэдэг үг нь хятадаар тайян. Монголын нууц товчоонд Наран хааныг Таян гэж бичжээ. С. Б.) Бэда улстай⁷ дайтахаар цэрэг хөдөлгөхөд Найманы жанжин Идэр тобу урьд өмнө хоёр удаа Бэда улсын газар найрсгаар очиж байсан тул,

— Тэдний сайн санааг нэвт мэднэ, ямарч байлаа хэрхэвч хорлохгүй гэсэнд Наран хаан уурлаж түүнийг цаазлах гэснээ өршөөж, дөчин удаа банздуулаад,

6 «Хөх судар» 562-р тал

7 «Бэда» гэдэг нь бид» гэсэн утгатай үг бөгөөд эрт дээр үед монголчууд өөрсдийгөө Бэда» гэж нэрлэж байсныг түүхийн сурвалж бичгүүдэд тэмдэглэжээ. Саган сэцэний эрдэнийн товчинд алс эртний монгол угсаатныг «Бада» гэж нэрлэсэн байна. Монголын нууц товчоо» -нд Чингис хааны язгуурыг дээр тэнгэрээс заяат Бертэ-чино (1957, 25-р тал) гэж үзсэн байхад Сүмбэ Хамба Ишбалжир Галбирвасан модон хэмээх түүхийн сурвалж бичигтээ . «Бэда аймгийнхан Бөртийг Бөртэ-чоно (301а-тал) хэмээн нэрлэжээ гэсэн нь Бөртэ-чонын гарал угсааг тодотгосон хэрэг. Инжинаш «хөх судар» –ын дотор «Бада» улсын нэрийг олонтаа хэрэглэжээ.

— Чи үхэхээс айхгүй мөртлөө байлдахаас татгалздаг нь юу юм бэ? гэхэд Идэр тобу,
— Мөхөс боол үхэхээс эс айна. Боол миний бөгс хэдий бөх боловч нүүр минь хэврэг гагцхүү эзэн өөрөө нэгэн нүүр бөх хүнийг илгээж боол намайг бусад алалдах байлдаанд илгээмүү гэжээ.

Зохиогч «Хөх судар» романдаа түүхэн бодит хүмүүсийн дүрээс гадна урьд өмнөх Монголын түүхэн зохиолд ховор тохиолддог эмэгтэйчүүдийн аж амьдрал, үзэл санааг тодорхой гаргасан юм. «Хөх судар»-т Солонго, Хонгорзул зэрэг үзэсгэлэн гоо, эрэлхэг зоригтой бүсгүйчүүл гардаг. Хонгорзул нас өндөр болсон эцгийнхээ оронд айлын ганц хүүгийн дүрээр ээмгээ чихнээсээ авч дайнд мордож байна. Цэргийн газар нэгэн эр түүний өнгө зүс олноос үзэсгэлэн гоо, мах арьс нэн булбарайд сэмээр сэтгэл тавин тэнсэхийг Хонгорзул хэдийн мэдээд дээл бүсээ сайтар батлана. Хэдийгээр шингэн мөр үзэх боловч адуун сүрэг бараадах тул морь гишгэлээд олноор мэдэж эс чадна. Хонгорзул дайн тулаанд хэнээс ч дутахгүй эрэлхэг зориг гаргаж Мухулай жанжинг сүрдэн бишрэхэд хүргэдэг.

Инжинаш бийрийн гүйдэлд үгийн урныг тодруулж Монгол бүсгүйн үзэсгэлэнг илэрхийлэхдээ нүд дүүрэн гал, хацар дүүрэн гэрэл, урт хасаар зүлгэсэн цэх сайхан хамар гээд уруулын улаан цус душлах шахам, бэлхүүс нарийн, өгүүлэх цөөн, алхах удаан, хөдөлж аашлахын зуур сонин нэгэн зүйлийн гоо үзэсгэлэн нуугдаж, хөмсөг хацрын хооронд гүн ухаан илэрнэ гэж бичсэн нь Инжинашийн хэлсэн

Хүний сэтгэлийг хөдөлгөн эс чадвал

Хөнгөн бийрийг хөшиж юу хийнэ гэсэн шүлгийн мөрийг санагдуулна.

«Хөх судар» нь түүх судлалын үнэт бүтээл бөгөөд уран зохиолын баялаг хэллэг, дүрслэх уран чадвар гойд шингэсэн роман юм. «Хөх судар»-аас монголчуудын авд гарах, чуулган чуулах, насны баяр тэмдэглэх, баатар эрсийг сорин шалгаруулах, сайшаан хөхүүлэх зэрэг XII—XIII зууны үеийн зан үйлийн олон талыг мэдэж болохоос гадна монголчуудын түүхийн мэдлэг, бичиг үсгийн боловсрол, орчуулгын чадварыг харж болдог. Тэгэхээр энэ роман нь ганц түүх судлалд төдийгүй нийгмийн шинжлэх ухааны бусад салбаруудад ч шууд холбоотой. Өнөө үед «Хөх судар» судлалын асуудал бий болсон нь уг зохиолын хэр зэрэг дорвитой бүтээл болохыг харуулж байна.

Инжинаш 1872—1882 онд «Нэгэн давхар асар» романаа бичжээ. Романы дэд дэвтэр нь «Улаанаа ухилах танхим» хэмээх нэртэй юм. Тэрбээр «Нэгэн давхар асар» романдаа тухайн үед гэр бүл болох нь эд хөрөнгө, эцэг эхийн мэдэлд оршиж байсныг илэн далангуй шүүмжилжээ.

Уг романд өгүүлэгдэх газар ус, хүний нэр хятад байгаа нь тэрбээр зохиолдоо тухайн нийгмийн доторх хамгийн хурц ээдрээтэй асуудлуудын нэгийг хөндөж гаргасан тул баяд ноёдын зүгээс гарах шүүмжлэлд өртөхөөс болгоомжилж хятад нэрээр төрсөн газар нутаг, халуун нүүр танил монгол хүмүүсийн нэрийг өнгөлөн далдалсных ажээ. Инжинаш бага залуу насандаа Харчин ван Цэвэгдоржийн охинтой амьдралаа холбохоор тохиролцсон боловч тэдний хайр сэтгэл тухайн үеийн ураг холбох ёсонд харшилан талаар өнгөрсөнд сэтгэлдээ гашуун шаналал үлдээсэн Инжинаш энэхүү зохиолыг өөрийн болон тэр үеийн залуусын амьдралаас үндэслэн зохиосон болох нь олон үйл явдлаар батлагддаг. Тухайлбал романы гол дүр Бо Юй шүлэг бичдэг бөгөөд түүний зохиосон «Цагаан үүл», «Жигшмээрт ху» шүлгийг Инжинаш «Нэгэн

давхар асар» романаа бичихээс өмнө зохиосон юм. Мөн түүнчлэн Бо Юй-н эцэг Бэй Хэ өмнө зүг хааны зарлигаар одож байгаа нь Инжинашийн эцэг Ванчинбал 1840—1842 оны «Хар тамхины» анхдугаар дайнд оролцохоор одсонтой тохирч байна. Романы зохиомж нь ч Монголын үргэлжилсэн үгийн зохиолын уламжлалт арга хэлбэрийг хадгалжээ. Зохиолын гол үйл явдал нь Бо Юй болон Чинь Мо, Лү Мэй, Шэн Жү гэдэг гурван эмэгтэйн амьдрал, янаг амрагийн холбоог үзэж сонссон хүний яриа буюу шууд дүрслэлийн аргаар өгүүлжээ. Романы тэргүүн дэвтэрт язгууртны охид хүвгүүдийн ордны амьдрал, Бо Юй гийн үзэл санааны зөрчил тэмцлийг харуулна. Зохиолын дэд дэвтэрт гурван бүсгүйг гэрийнхэн нь алт мөнгөөр сүй тавин худалдсанд Лү Мэй хөгшин нөхрөөсөө зайлж царай, төрхөө өөрчлөн явсаар нэгэн айлын хүү болдог. Чинь Мо хайр сэтгэлгүй хүний эхнэр явснаас үхсэн нь дээр гэж мөрний усанд харайн орох боловч нэг хүн түүнийг аварч охиноо болгодог. Чинь Мо удалгүй хадамд гарч төрхөө өөрчилсөн Лү Мэй-тэй «ураг барилдан» хоёр бүсгүй учирна. Бо Юй нөхрөөсөө бэлбэсэрсэн Шэн Жу-тэй ханилан, зовж ядарч яваа хоёр бүсгүйг олж гурван эхнэртэй болж байгаагаар зохиол төгсдөг. «Нэгэн давхар асар» роман нь нийгмийн дунд, доод давхаргын төлөөлөгчдийн бодит амьдралаас эх сурвалжтай бичигдсэнээрээ монголын уран зохиолын түүхийн хуудаснаа тэмдэглэгдэн үлдсэнийг дурдалгүй өнгөрч болохгүй юм.

Их зохиолч Инжинаш зохиол бүтээлээ туурвиж байгаад 1892 оны 2-р сарын 25-нд 55 насан дээрээ таалал төгсчээ. Инжинаш манж, төвд, хятад хэлний өндөр боловсролтойгоос гадна эх монгол хэлээ төгс эзэмшсэн төдийгүй эрхэмлэн хайрладаг түүгээр бахархдаг хүн байлаа. Улс үндэстний хэл бол тухайн үндэстний ард түмний эрхэм нандин соёл байтал Өвөрлөгч хошууны зарим хүмүүс Манж Чин улсын хятадчилах бодлогын нөлөөнд автаж, нэгэн хоёр иргэн (хятад) үсэг мэдэж авбал монгол хэл бичгээ үл тоомсорлон, монгол зан заншил ёс суртахуунаа мартаж буйд харамссан Инжинаш төрөлх монгол үгийнхээ баялгийг далайтай адилтган тэдгээр хүмүүсийг «далайн хөвөөнд биеэ угаагаад далайг гүехэн үзсэнээс юун өөр аж»⁸ хэмээн зэмлээд «Улс улсын зан суртлын аяыг дагаж бичиг судрын их аяс, зан төлөвөөр өөр байх нь .. олон зүйлийн өнгө бүхий цэцэг адил сайхан, ... жимс адил амттай, иргэн үсэг сүүл даран хэлж, монгол үсэг толгой холбон өгүүлэх ба төвд үсэг түргэн дөтийг эрхэлж, манж үсэг тус тохируулан зохиогджээ.»⁹ хэмээн эдгээр хэлний адил тэгш эрх, онцлогийг тодорхойлсон байдаг.

Инжинашийн зохиолууд нь монголчуудын дунд гар бичмэлээр дам жин уншигдаж байснаас гадна Ж. Цэвээний мэдээлснээр «Хөх судар» ын 15 дэвтэр 1909 онд Петербургийн номын санд хадгалагдаж байжээ.¹⁰ 1930—1950-иад онд В. Инжинашийн «Хөх судар», «Нэгэн давхар асар» романууд болоод шүлэг, өгүүллэгийн түүврүүд нь Өвөр Монголд удаа дараалан хэвлэгдэж байсан юм. БНХАУ-ын ӨМӨЗО-ы Ардын хэвлэлийн хорооноос 1957 онд «Нэгэн давхар асар» романыг 2 дэвтэр 52 бүлэгтэйгээр, «Хөх судар» романыг Өвөр Монголд 1938 онд хэвлэгдсэн эхийг засч найруулан 1957, 1982 онд гурван дэвтэр хэвлүүлэв. 1981 онд Х. Буянбат Инжинаш ба түүний «Хөх судар»-ын

8 «Хөх судар» 15-р тал

9 «Хөх судар» 1982 он. 52—53-р тал

10 «Монголын уран зохиолын тойм». 111 дэвтэр. 83-р тал

тухай гэсэн уран зохиолын судалгааны номыг хэвлүүлсэн юм. ЗХУ-ын Г. Михайлов, С. Неклюдов, К. Яцковская, Л. Скородумова зэрэг утга зохиол судлалчид Инжинашийн уран бүтээлийг олны хүртээл болгох талаар их ажил хийж байна. Тухайлбал Л. Скородумова «Нэгэн давхар асар», «Улаанаа ухилах танхим» романыг орос хэлээр хэвлүүлснээс гадна «Хөх судар» романыг орчуулж байна. Инжинацийн уран бүтээлийг Америкийн монголч эрдэмтэн Хангин Гомбожав, ХБНГУ-ын Монголч эрдэмтэн Вальтер Хайссиг нар судалж хэд хэдэн ном, өгүүлэл бичсэнээс Хангин Гомбожав Инжинашийн «Хөх судар»-ын уран зохиолд эзлэх байр суурь сэдвээр Индиан Их сургуульд докторын зэрэг хамгаалжээ.

Инжинашийн уран бүтээл нь манай улсын ерөнхий боловсролын дунд сургуулийн Монголын уран зохиолын хичээлийн хөтөлбөрт зүй ёсоор ордог бөгөөд Монголын утга зохиол судлагч эрдэмтэн мэргэд Инжинашийн зохиол бүтээлийн талаар хэд хэдэн ном бичсэн юм. Академич Ц. Дамдинсүрэн «Монголын утга зохиолын дээж зуун билэг» гэдэг эмхтгэлдээ Инжинашийн «Хөх судар»-ын оршил «Товчит тольтын» гуравдугаар бүлгийг мөн романы гучин гуравдугаар бүлгийн хамт товч тайлбартайгаар хэвлүүлж, Г. Жамсранжав «Монголын уран зохиолын тойм»-ын III дэвтэрт «Хөх судар», «Нэгэн давхар асар» рома нуудын агуулга, үзэл санаа, дүрүүдийг задлан шинжилсэн нь В. Инжинашийн уран бүтээлийг судлахад чухал хувь нэмэр болсон юм.

В. Инжинаш зохиол бүтээлээ ид туурвиж байх үедээ;

Мянган оны учир шалтгааныг бийр бэхсээс асууж

Мяралзан эрээлжлэх үйл явдлыг судар бичиг лүгээ хэлэлцмүй

Миний энэ бие хэл сэтгэлийн гүнээ чилсэн шалтгааныг

Мятаршгүй хожмын мэргэд мэднэм болов уу үгүй юү гэж хойч үедээ зохиол бүтээлээ тайлагнасан байдаг.

Инжинаш нийгмийн үзэгдлийг өнгөрсөн ба тухайн үетэйгээ харьцуулан гярхай ажиглан бодит үнэнд тулгуурласан олон сайхан зохиол туурвиж, Монголын түүх, уран зохиолын сан хөмрөгт үнэт хувь нэмэр оруулсан нь олон үеийн уншигч түмний сонирхолд нийцэхүйц болж чадсан тул он цагийн шалгуурыг даван уламжлагдсаар байна.

С. Баасанжав

ПОЛЬШИЙН НЭРТ МОНГОЛЧ ЭРДЭМТЭН

Оросын болон гадаадын эрдэмтэд дээр үеэс эхлэн Монголын газар орон, түүх, эдийн засаг, хэл, утга зохиол, угсаатны зүйг сонирхон судалсаар ирсний дотор олон эрдэмтэд дорно дахины судлал тухайлбал Монгол судлалд үнэт хувь нэмэр оруулжээ. Тэдгээрийн нэг нь Польшийн нэрт монголч эрдэмтэн Владислав Людвигович Котвич юм.

Түүний эрдэм шинжилгээний үйл ажиллагаа бүхэлдээ XX зууны тэргүүн хагасад хамаарагдах бөгөөд тэр үед монгол судлал нь Европын Дорно дахины судлалын ухаанд бие даан хөгжиж байсан салбар юм. Орос оронд олон жил сууж дорно дахиныг судлах мэдлэг боловсрол олж авсан О. М. Ковалевский, В. Л. Котвич нарыг Польш дахь Монгол судлалын үндсийг тавигчид гэж зүй ёсоор үздэг байна.¹ Нэрт эрдэмтэн В. Котвич Польшийн шинжлэх ухааны академийн гишүүн, ЗХУ-ын ШУА-ийн сурвалжлагч гишүүн, БНМАУ-ын Шинжлэх ухааны хүрээлэнгийн жинхэнэ гишүүнээр тус тус сонгогдож байжээ.

В. Котвич 1872 онд Вильна хотод төрж тус хотноо дунд сургууль төгсгөжээ. В. Котвич 1891 онд Петербургийн их сургуулийн Дорно дахины хэлний ангид орж, А. Ивановский, В. Васильев, К. Голстунский, А. Позднеев нарын зэрэг Оросын нэрт эрдэмтдээр багшлуулж 1895 онд төгсчээ. Тэрээр турк, төвд, солонгос хэл сайн мэддэг байжээ. В. Котвич их сургуулиа төгсгөсний дараа Сангийн яаманд ажиллаж байсан боловч дорно дахины хэлний факультеттай ямагт холбоотой байв.

XIX зууны 90-ээд онд Хятад-Манж-Монголын салбарт авьяас билэг төгөлдөр 4 оюутан тодрон гарсан тул тэднийг профессорт бэлтгэхээр Монгол, халимагийн уран зохиолын тэнхимд үлдээжээ. Гэтэл тэдний Г. В. Подставин, Г. Ц. Цыбиков нар А. М. Позднеевийн урилгаар Владивостокт явж, В. Л. Котвич, А. Д. Руднев хоёр Санкт-Петербургийн дорно дахины хэлний факультетэд үлдэж ажиллах болжээ.

1900 оны хавар тус факультет В. Котвичийг Монголын уран зохиолын хичээл заалгахаар доцент-багшаар урьсан бөгөөд В. Котвич энд ирээд сургалтын программыг өөрчлөн шинэчилжээ. В. Котвич монгол хэлний харьцуулсан хэл зүй, монгол хэлний дайвар үг, Монголын засаг захиргааны байгууламж, албан бичгийн эх зохиох тухай хичээл зааж байв.

1900 онд дорно дахины хэлний факультетийн эрдмийн зөвлөл В. Котвичид тус факультетийг даалгах нь зүйтэй гэж санал нэгтэй

1 Культура Монголии в средние века и новое время, Улан-Удэ, 1986, стр. 134.

үзжээ. Тэрээр 1900 онд доцент цол хүртэж, факультетийн монгол хэл болон 1903 оноос манж хэлний кафедрийг тус тус толгойлох болов.

В. Котвич 1908 оноос манж хэлийг зааж эхэлсэн бөгөөд манж хэлний унших бичиг зохиожээ. Үүний хамт бас Монгол, Халимаг, Манж уран зохиолын лекц уншиж байв.

В. Котвич Октябрийн хувьсгалын дараа Ленинград хотноо дорно дахины амьд хэлний дээд сургуулийг үүсгэн байгуулахад идэвхтэй оролцож түүний анхны захирал болжээ.

В. Котвич 1896 оноос 1922 оныг хүртэл Петербургийн их сургуульд эрдэм шинжилгээний болон багшийн ажил хийж байгаад дараа нь Ленинградын Дорно дахины, одоогийн хэлний институтын захирлаар 1924 он хүртэл ажиллаж байв.

Гэвч тэрээр удалгүй 1924 онд Львовийн их сургуулийн урилгаар эх нутагтаа очиж тус их сургуулийн нийгмийн ухааны факультетийн Алс Дорнодын кафедрийг удирдаж манж, монгол хэл болон Дундад ба Төв Азийн нүүдэлчин ард түмний түүхийн талаар лекц уншиж байв.

Профессор В. Котвич Львов, Вильна зэрэг хотод Дорнодахины ба Алтай судлалын кафедрийг тус тус байгуулжээ. Тэрээр Львов хотын Алс дорнодын их сургуулийн хэл бичгийн тэнхимийн эрхлэгчээр олон жил ажиллаж байсан бөгөөд Варшав хотноо Польшийн монгол судлалын сургуулийг үндэслэн байгуулжээ. Гэвч тэрээр Оросын монголч эрдэмтэдтэй байнга харилцаатай байсан юм.

В. Котвич бол Польшийн монгол судлалын нэрт төлөөлөгчийн нэг мөн. Тэрээр Петербург хотноо багшлахын зэрэгцээ эрдэм шинжилгээний ажлыг үр бүтээлтэй хийж байсан билээ. В. Котвич Польшийн Дорнодахины судлалыг үндэслэн байгуулахад ихээхэн гавьяа байгуулсан бөгөөд тэрхүү Дорнодахины судлалын нийгэмлэгийн анхны даргаар сонгогдож насан эцэс болтлоо ажиллаж байв. 1931—1938 оны хооронд тус нийгэмлэгийн 7 их хурал хуралджээ. Мөн В. Котвичийн санаачлагаар Алтай судлалын «Рочник Ориенталистичный» хэмээх сэтгүүл гарч түүнд Алтай судлал, түүний дотор Монголсудлалын талаар сонирхолтой олон бүтээл нийтлэгдсэн байна. Тэрээр Петербургийн их сургуульд 30 орчим жил ажиллахдаа монгол судлалын холбогдолтой эрдэм шинжилгээний олон арван бүтээлийг туурвижээ.

В. Котвич эрдэм шинжилгээний гол гол бүтээлээ Польш улсад нийтэлсэн бөгөөд нийт 140 гаруй зохиолыг гол төлөв польш, орос, франц хэлээр хэвлүүлжээ.

Тэдгээрийн дотор «Монголын цаг тооллын бичиг», «Монголын утга зохиолын түүх, манжийн түүх» (хоёр боть) гэх зэрэг монгол судлалын талаар олон зохиол орсон байна. Тэрээр 1912 онд Баруун Монголд эрдэм шинжилгээний ажлаар ирж Монгол хэлийг судалж байв. Мөн Эрдэнэ зуугийн монгол бичгийн дурсгал, Монгол нутаг дахь туркийн үеийн урьд мэдэгдээгүй бичгийн дурсгал зэргийг олж хэвлэн нийтлүүлсэн ажээ.

В. Котвич Монгол бичгийн дурсгалуудыг судлахад их анхаарал тавьж, монгол хэл, Монголын түүхийг судлахад чухал ач холбогдолтой «Персийн ил хаадын захидлыг задлан шинжилж залруулах нь» (1925), «XIII-XIV зууны үеийн монгол бичгийн дурсгалыг шинээр нээн илрүүлсэн нь» (1909) зэрэг томоохон бүтээл бичсэн юм.

В. Котвич Монголын түүхийн дурсгалт зүйлийг олж нийтлүүлэхээс гадна «Монголын утга зохиолын хэлний зүй» (1902), «Халимаг ярианы хэлний зүй» (1915—1929), «Ган-су мужийн Шар уйгурын Монгол хэл» (1939) зэрэг зохиолуудыг бичжээ. Тэрчлэн В. Котвич Алтай суд-

лалд их хувь нэмэр оруулсан юм. Тухайлбал 1950 онд Польш хэлээр, 1962 онд орос хэлээр тус тус нийтлэгдсэн «Алтайн хэлнүүдийн судалгаа» хэмээх номондоо турк, монгол, манж-тунгус хэлний харилцааны тухай асуудлыг нягт судлан боловсруулжээ.

В. Котвич Оросын болон Польшийн монгол судлаачдыг бэлтгэхэд их санаа тавьж байсан бөгөөд тэрээр 1913—1915 онд Баруун Монголоор явах Б. Я. Владимирцовын эрдэм шинжилгээний ажлын хөтөлбөрийг боловсруулж өгч байжээ.

В. Котвич Монголын эрх чөлөөний хөдөлгөөнд талархаж, монгол хэл, Монголын байдлыг сайн мэддэг байсан учир Монголд ирж монголчууд ялангуяа тусгаар тогтносон Монгол Улсын эрх баригчид, улс төрийн зүтгэлтэн Да лам Цэрэнчимэд, Чин Ван Ханддорж, Хайсан гүн, Сайн ноён Намнансүрэн зэрэг нөлөө бүхий хүмүүсийн итгэлийг олж тэдэнтэй бичиг захидлаар үргэлж харилцдаг байжээ. В. Котвич: «Бээжингийн засгийн газрын колоничлох бодлого 1911 онд Ар Монголыг ч хамаарах болж байв. Түүний өргөн их нутгийг хятад хүнд эзэмшүүлэх ба Да хүрээнд цэрэг хуарагнуулах ажил явагдаж байв. Үүнийг халхчууд эрх чөлөөнд заналхийлж байна гэж Бээжингийн засгийн газрын энэхүү хууль бус явууллагыг эсэргүүцэж эхлэв.

Халхчууд шашны тэргүүн, Да хүрээний Богд гэгээнийг тойрон хүрээлж эрх чөлөө, сонирхлоо хамгаалахад дэмжлэг эрж орос улсад төлөөлөгчөө явуулсан юм² гэж бичжээ.

Монголын түүхч академич Б. Ширэндэв В. Котвичийн архивын материалын зарим хэсгийг удиртгал, товч тайлбарын хамт хэвлэн нийтэлжээ.³ В. Котвичийн архиваас олж нийтлүүлсэн гар бичмэл нь Монгол Улсын тэр цагийн гадаад харилцааг судлахад нэлээд олон асуудлыг тодруулан өгөх чухал ач холбогдолтой материал юм.

В. Котвичийн эрдэм шинжилгээний ажлын сонирхол, цар хүрээ, өргөн, олон талтай. Тэрээр нэрт монголч, халимаг судлалч, манжич хүн байв. В. Котвичийн дорно дахины хэлний факультетэд уншиж байсан монгол хэлний хэл зүйн лекц нь чулуун бараар хэвлэгджээ. В. Котвич бүр оюутан болон магистр байхдаа халимаг хэлийг байнга судалж аман зохиолын материал цуглуулдаг байжээ. Түүний судалгааны үр дүнд «Халимаг оньсого ба зүйр цэцэн үг» (1905). «Халимагийн ярианы хэлний хэл зүйн дадлага» (1915) зэрэг ном нийтлэгдсэн байна. Түүний санаачлагаар халимагийн тууль «Жангарыг» тэмдэглэн бичиж үлдээжээ.

В. Котвич «XVII—XVIII зууны үед ойрадуудтай харилцаж байсан тухай Оросын архивын баримт» (1919), Монголын түүхийн тухай «Монголын орчин үеийн улс төрийн байдал ба түүхийн товч тойм» (1914) гэдэг бэсрэгхэн зохиол бичсэн юм. В. Котвич Төв Азийн ард түмний түүхийн талаар хэд хэдэн зохиол бичсэний гадна мөн Польшийн монгол судлалын түүхийг судалж монголч эрдэмтэн О. Ковалевский болон бусад эрдэмтдийн дэлгэрэнгүй намтарыг бичжээ.

«Одоогийн халимаг хэлний тийн ялгал» (1918), «Юань-чао-би шийн хэвлэлт» (1925), «Монголын он тэмдэглэлийн тухай» (1926, 1928) зэрэг зохиол монголч судлагчдын анхаарлыг зүй ёсоор татаж байна. Тэрээр амьдралынхаа сүүлийн үед турк, монгол, манж, тун-

2 В. Л. Котвич. Краткий обзор истории и современного политического положения Монголии. Петербург, 1914 г.

3 Б. Ширэндэв, В.Л. Котвичийн хувийн архиваас олдсон монголын түүхэнд холбогдох зарим бичиг. УБ., 1972.

гус зэрэг алтайн хэлүүдийг харьцуулан судалж, хэл шинжлэлийн олон сонирхолтой өгүүлэл бичжээ. Түүний дорнодахины судлалын талаар бичсэн үнэ цэнэтэй олон арван зохиол хэвлэгдсэн боловч мөн олон зохиол нь гар бичмэл хэвээр хадгалагдаж эдүгээ эрдэмтдийн судалгаа шинжилгээний хэрэглэгдэхүүн болсоор байна.

Польшийн дорнодахины судлалд түүний бүтээсэн гавьяа их билээ. Тэрээр Польшийн дорнодахины судлалыг хөгжүүлэхэд зөвхөн өөрийн оюун ухаан, хүч хөдөлмөрөө зориулсан төдийгүй уг үйл хэрэгт хувийн мөнгө, хөрөнгөө хүртэл харамгүй зарцуулж байжээ. Тухайлбал «Рочник ориенталистычный» хэмээх сэтгүүлийг хэвлэн гаргахад улсаас хөрөнгө мөнгө хүрэлцэхгүй болсон тул «Коллектанеа ориенталиа» гэдэг цуврал сэтгүүлийг өөрийн мөнгөөрөө хэвлэн нийтэлж нийт арван зургаан дугаарыг гаргасны дотор Монгол судлалын холбогдолтой олон зохиол хэвлэн нийтлэгджээ.

Оросын монгол судлалыг хөгжүүлэхэд хүчин зүтгэсэн гарамгай эрдэмтдийн нэг нь Польшийн нэрт монгол судлаач В. Котвич билээ. Түүний алдар нэр зөвхөн Орос, Польшийн монгол судлалд төдийгүй зөвлөлтийн шинжлэх ухаан ба дэлхийн монгол судлалд бахархал болон үлджээ.⁴

Б. Дорж

4 Культура Монголии в средние века и новое время: Улан-Удэ. 1986, стр. 156.

**НЭРТ МОНГОЛЧ ЭРДЭМТЭН
БОРИС ЯКОВЛЕВИЧ
ВЛАДИМИРЦОВ.**

Зөвлөлтийн нэрт монголч эрдэмтэн Б. Я. Владимирцов Дэлхийн марксист монгол судлалын тулгын чулууг тавилцсан гавъяат эрдэмтний нэг бөгөөд тэрээр угсаатны зүйч, хэл шинжээч, нэрт түүхч юм.

Борис Яковлевич Владимирцов 1884 оны 7-р сарын 20-нд Калуга хотын орчим төржээ. Түүнийг 1904 онд гимназ төгсч байх үед Орос Японы дайн эхэлж бүх нийтийн анхаарал дорно зүгт ханджээ. Б. Я. Владимирцов ч цаг үеийн шаардлагыг соргоогоор тусган авч дорнодахиныг судлагч болохоор шийджээ. Тэр үед Петербургийн их сургуулийн Дорнодахины факультетийг Б.Я. Котвич, А.Д. Руднев нарын зэрэг нэрт эрдэмтэд удирдаж байсан бөгөөд тэдэнтэй уулзсан үеэс эхлэн Борис Яковлевич эргэлтгүйгээр монгол судлаач болохоор шийджээ. Энэ үеэс эхлэн Борис Яковлевич монгол судлалын ажилд бие сэтгэлээ зориулж Монголын ард түмний угсаатны зүй, хэл шинжлэл, түүх соёлыг судлах нөр их ажилд ухамсарт бүх амьдралаа зориулжээ.

Б. Я. Владимирцов оюутан байх үеэсээ эрдэм шинжилгээний ажлаа эхэлж 1907 онд Астраханий халимаг, 1908 онд Баруун Монголоор явсан экспедицид оролцож Монголын ард түмний ахуй байдал, зан заншил, аман зохиол, хэл, соёлын баялаг өвтэй биеэр танилцсан нь хожим түүнийг үнэ цэнэтэй бүтээлээ туурвихад өргөн бололцоо олгосон юм.

Ийнхүү монголчуудын аман зохиолын баялаг өв сантай биечлэн танилцсанаар Энэтхэг Төвдөөр дамжин монголчуудын дунд тархсан Панчатантрын үлгэрийн монгол хувилбарыг (1921) анх удаа бүрэн эхээр нь хэвлэж өрнө дахины уншигчдын хүртээл болгожээ. Мөн баруун Монголын олон сайн туульчидтай уулзан учирч Монголын аман зохиолын оргилын нэг болсон олон сайхан туульсийг тэмдэглэн авч 1923 онд «Ойрад Монголын баатарлаг туульс»-ыг хэвлүүлжээ. Хожим туульсын орос орчуулгыг дэлгэрэнгүй оршилын хамт хэвлүүлсэн нь Монголын аман зохиолыг дэлхийн түвшинд гаргаж тавьсан төдийгүй монгол үлгэр, туулийг орос хэлнээ орчуулахын гайхамшигт жишээ болжээ. Монгол ардын аман зохиол, утга зохиолыг нарийвчлан судалж «Монголын утга зохиолын лекц» (1920), «Шидэт хүүрийн үлгэр» Монгол ардын аман зохиолын жишээ (1926), «Халхын Цогт тайжийн хадны бичиг» (1926) зэрэг олон сонин өгүүлэл товхимол хэвлүүлсэн бөгөөд эдгээр бүтээлдээ Монгол, Төвд, Энэтхэгийн утга зохиолын харилцааны тухай сонирхолтой санал дэвшүүлжээ. Б. Я. Владимирцов эдгээр бүтээлээрээ монгол судлалд аман зохиол, утга зохиол судлалын үндсийг тавьсан юм.

Б.Я. Владимирцов Судар бичгийн хүрээлэнгийн ажилд туслахаар 1925, 1926 онуудад БНМАУ-д ирээд байхдаа Хэнтий, Богд хан уулын нутгаар экспедицээр явж Шинжилгээний арвин их материал цуглуулсны дүнд 1929 онд «Монгол бичгийн хэл, Халх аялгууны харьцуулсан хэл зүй» хэмээх дорвитой бүтээлээ туурвижээ. Борис Яковлевич энэ зохиолдоо Монгол бичгийн хэлний хөгжлийг үечлэн хувааж, авиан зүйн тодорхойгүй олон асуудалд хариу өгсний зэрэгцээ, монгол хэлний түүхэн хөгжилтэй холбогдсон үндэслэлтэй олон шинэ саналыг дэвшүүлсэн бөгөөд мөн монгол бичгийн хэлний хөгжлийн түүх, Монгол хэл түүний олон салбар аялгуу, тэдгээрийн хоорондын холбоог задлан шинжилсэн олон арван эрдэм шинжилгээний өгүүлэл бичсэн нь монгол хэл шинжлэлийг шинжлэх ухааны өндөр түвшинд гаргажээ.

Б. Я. Владимирцов нь гол бүтээлээ түүхийн салбараар туурвисан бөгөөд түүний «Төвд, Монгол дахь Буддизм (1919), «Чингис хаан» (1922), «Халхын таван отог хаана байна» (1930) зэрэг бүтээлүүд нь Монголын түүх судлалд зохих хувь нэмрээ оруулсан юм.

Түүний бүтээлийн гайхамшигт оргилын нэг бол «Монголчуудын нийгмийн байгуулал, Монголын нүүдлийн феодализм» хэмээх зохиол юм. Зохиогч энэ бүтээлдээ XI—XVI зууны монголчуудын нийгмийн харилцааг нягтлан Дэлхий дахины түүх бичлэгт нүүдэлчдийн феодалын харилцааны асуудлыг анх удаа марксист байр сууринаас авч үзсэн бөгөөд энэ зохиол нь эдүгээ хүртэл эрдэм шинжилгээний үнэ цэнээ алдаагүйгээр үл барам монголсудлалын шинжилгээний сан хөмрөгт хүндтэй байр сууриа эзэлсээр байна.

Б. Я. Владимирцов нь монгол хэлийг нэн сайн эзэмшсэний дээр өрнө дорнын олон хэлийг мэддэг байсан болон Англи, Франц зэрэг орноор явж монголч эрдэмтэдтэй уулзан саналаа солилцож, тэдгээр улсын сан хөмрөгт хадгалагдан буй Монголын холбогдолтой материалтай биечлэн танилцаж байсан нь түүний судалгааны ажлын цар хүрээг өргөн далайцтай болгожээ.

Академич Борис Яковлевич Владимирцовын туурвисан эрдэм шинжилгээний 70 орчим бүтээлийн нэлээд хэсэг нь өрнө дорнын олон хэлээр орчуулагдсан нь монгол судлалын хөгжилд зохих ёсоор нөлөөлжээ.

Б. Я. Владимирцовын монгол судлалыг хөгжүүлэхийг чармайж байсны нэг илрэл нь Монгол дахь шинжилгээний байгууллагыг өсөж өндийхөд нь зүйл бүрээр тусалж байсан явдал юм. Тэрээр Судар бичгийн хүрээлэнгийн судалгаа шинжилгээний материаллаг баазыг бэхжүүлэхэд анхаарч тус хүрээлэнгийн хүсэлтээр франц, англи, герман зэрэг өрнө дахины хэлээр буй Монголын холбогдолтой материалыг цуглуулан олон зуун төгрөгийн ном зохиолыг илгээж байжээ. Үүний зэрэгцээ Борис Яковлевич Монгол нутгаар хээрийн шинжилгээний ажлаар явж байхдаа Монголын шинжлэх ухааны байгууллагын залуу ажилтан нарыг эрдэм судалгааны нарийн төвөгтэй ажилд биеэр заан, сургаж байсан гавъяатай эрдэмтэн юм.

Монгол судлалд түүний оруулсан хувь нэмрийг Монголын шинжлэх ухааны байгууллага зүй ёсоор үнэлж 1924 оны 5-р сарын 9-ний хурлаар Судар бичгийн хүрээлэнгийн гадаад дахь гишүүн болгожээ. Б. Я. Владимирцов нь Монгол судлалын аль нэг салбараар бус түүх, угсаатны зүй, хэл шинжлэл, аман ба утга зохиол, сурвалж бичиг судлал зэрэг шинжлэх ухааны олон салбарыг гарамгай эзэмшиж салбар бүхэндээ үнэтэй хувь нэмэр оруулсан авъяас билигтэй эрдэмтэн байсан юм. Түүний шинжлэх ухаанд оруулсан жинтэй хувь нэмрийг өнд-

рөөр үнэлж 1918 онд доцент, 1921 онд СССР-ийн ШУА-ийн сурвалжлагч гишүүн, 1929 онд академич цолоор тус тус шагнаж байжээ.

Б. Я. Владимирцов 1909 онд Петербургийн их сургуулийг төгсч Монгол хэлний тэнхимд багшлах болсон цагаасаа эхлэн судалгаа шинжилгээнийхээ нөр их ажлын зэрэгцээ монгол судлалын мэргэжилтэн бэлтгэх ажилд хүчин зүтгэж эхэлсэн бөгөөд Монгол судлалын залгамж үеийг бэлтгэсэн хүндтэй гавъяа зүй ёсоор түүнд оногддог юм.

Борис Яковлевичийн туурвисан зохиол нь тухайн үеийн монгол судлалын тулгамдсан асуудлуудад хариу өгсөн дорвитой бүтээлүүд байсан бөгөөд түүний нөр хичээнгүй ажиллагаа нь Монголын түүх соёлыг судлах явдлыг дэлхийн түвшинд гаргаж тавьсан юм. Б. Я. Владимирцов судалгаа шинжилгээний ажлынхаа ид цэцэглэлтийн үед 1931 оны 8-р сарын 17-нд харамсалтайгаар нас барсан боловч Монголын ард түмэн, Монголыг судлагч хэн бүхний сэтгэл зүрхэнд гандан бууршгүй бүтээлээрээ мөнхрөн үлдсэн билээ.

С. Цолмон